

## ХЯТАДЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

М.Эрдэнэбаяр

ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн  
эрдэм шинжилгээний ажилтан, доктор (PhD)

**Товч агуулга:** БНХАУ 1978 оноос өөрчлөлт, шинэчлэлийн бодлого хэрэгжүүлснээр тус улсын эдийн засаг 30 гаруй жил тогтвортой өндөр өсөлтийг үзүүлж олон үзүүлэлтээр дэлхийд тэргүүлж эхэллээ. Төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засаг руу аядуу шилжилт хийж, тариачдын хэрэгцээг дэмжих, зах зээлээ нээх, төвлөрлийг сааруулах, хувийн хэвшлийг хөгжүүлэх зэрэг бодлого, арга хэмжээ хэрэгжүүлсэн нь эдийн засгийн өсөлтийг хангахад голлох нөлөө үзүүлжээ. Сүүлийн үеийн хөгжлийн бодлогын чиг хандлага нь зөвхөн эдийн засгийн өсөлтийг бус чанартай хөгжлийг, хүний хөгжил, ногоон хөгжил зэрэг үндэсний хөгжлийн бусад үзүүлэлтийг чухалчлах, цаашид модернизац, зах зээлийн төгөлдөршлийг бий болгохыг зорьж байна.

**Түлхүүр үг:** Хятадын хөгжлийн бодлого, хятадын хөгжлийн загвар, зах зээлийн эдийн засаг, эдийн засгийн бүтцийн шинэчлэл

### Өмнөх үг

БНХАУ-ын сүүлийн 30 гаруй жилийн “шинэтгэл, нээлттэй бодлого”-ын явцад тус улсын ДНБ хоёр оронтой тоогоор өсч, 1999 дунд орлоготой, 2010 онд дундаас дээгүүр орлоготой орнуудын эгнээнд орсон. 2009 онд тус улсын ДНБ Японоос давж дэлхийн 2 дахь том эдийн засаг, 2010 онд тус улсын экспорт Германаас давж, дэлхийн хамгийн том экспортлогч болжээ. 2019 оны байдлаар тус улсын ДНБ 14.3 их наяд ам.долларт хүрч дэлхийн нийт ДНБ-ний 16.3%-ийг бүрдүүлж байна. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засаг руу шилжилт хийсэн нь Хятадын эдийн засгийг өсгөх гол хүчин зүйл болсныг дийлэнх судлаачид хүлээн зөвшөөрдөг. Хятадын хөгжлийн бодлого, хувьсал өөрчлөлтийг судлах шаардлага бидний хувьд зайлшгүй юм. Энэ өгүүлэлд тус улсын явуулж ирсэн хөгжлийн бодлого, цаашдын чиг хандлагыг том зургаар харж, дүн шинжилгээ хийхийг зорив.

## Нэг. Хятадын хөгжлийн загвар

БНХАУ-ын эдийн засгийн хөгжлийн амжилтаас үүдэн Хятадын загвар гэх ойлголт бий болсон, ерөнхийдөө судлаачдын нэг хэсэг нь хэдийгээр хятадын загвар өөрийн гэсэн онцлогтой, тодорхой амжилтад хүрсэн ч бүрэн төлөвшөөгүй, болгоомжтой хандах шаардлагатай, нөгөө хэсэг нь Хятадын болон Барууны орнуудын хөгжлийн загвар дэлхийд ноёрхохын төлөө өрсөлдөж байна гэж үздэг, товчдоо, Хятадын загварыг авторитар дэглэмийн дор зах зээлийн эдийн засгийг хөгжүүлж буй загвар (төрийн капитализм) хэмээн тодорхойлж байна.

Хятадын хөгжлийн загвар дараах голлох онцлогтой байна:

- **Төрийн удирдлага голлосон.** Төр эдийн засгийн өсөлтийг дэмжихэд гол үүрэг гүйцэтгэж ирсэн. Засгийн газрын оролцоо, хяналт (макро бодлогын хяналт, төрийн өмчийн ААН-ийн шууд хяналт г.м) эдийн засгийн хөгжлийн чухал хүчин зүйл гэж үздэг.<sup>1</sup> Тухайлбал, үндэсний томоохон корпорациудыг бий болгохын тулд төрөөс эдийн засгийн зарим салбарт стратегийн зохицуулалт хийж байна.
- **Хөгжлийг нэн тэргүүний зорилт болгодог.** Ардчилсан тогтолцоо, хувийн эрх чөлөөг хангахаас өмнө тогтвортой байдал, эдийн засгийн хөгжлийг чухалчилсан. Эдийн засгийн өндөр хөгжил бий болсноор бусад олон асуудал аяндаа шийдэгдэнэ гэж үздэг.<sup>2</sup>
- **Сайн засаглал.** Хятадын бүх түвшний шинэтгэлийн практикт тусгалаа олсон байдаг. Төрийн албан хаагчдаа сургахад Сингапураас туслалцаа авсан, сургалтын хөтөлбөр нь эдийн засгийн бодлого, төслийн менежмент, олон нийтийн удирдлага, авлигатай тэмцэх зэрэг засаглалын олон төрлийн агуулгыг багтаадаг. Мэргэжлийн болон техникийн туршлагыг Сингапураас Хятадад шилжүүлэх систем бий болсон.
- **Аажим, прагматик шинэтгэл.** Хятадын шинэтгэл үе шаттай, хэсэгчилсэн байдлаар хийгдсэн, эдийн засгийн либералчлал, улс төрийн консерватизмаас бүрдсэн хэсэгчилсэн реформ хэмээн нэрлэдэг.<sup>[1]3</sup>
- **Инновацийг чухалчилсан.** Хятадын эдийн засгийн хөгжил аажмаар хөрөнгийн болон хөдөлмөрлөх хүчний орцоос инновацийн хөдөлгүүртэй хөгжил рүү шилжиж буй. Инновацид суурилсан цогц системийг бий

---

1 Эрх мэдлийн хуваарилалтын хувьд, ХКН улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын бүхий л салбарт өргөн хүрээтэй, төвлөрсөн удирдлага, шийдвэр гаргах эрх мэдэлтэй. Эдийн засгийн хувьд төрөөс түүхий эд, нөөцийн хуваарилалтын эрхийг зах зээлд шилжүүлж, зах зээлийн зарчмаар түүхий эдийн үйлдвэрлэл, эргэлтийг зохицуулдаг, төвлөрлийг сааруулах хандлагатай.

2 Ши Жиньпин “Үндэсний зорилгодоо хүрэхийн тулд хувь хүний улс төрийн эрх чөлөөнд шинэ хязгаарлалт тавихын зэрэгцээ зах зээлийн гүнзгий шинэтгэлийг хэрэгжүүлэхэд ямар ч зөрчилгүй” гэж үзэж буй.

3 Үндсэндээ шилжилтийн 2 аргачлал байдаг, “биг банг” болон консерватив. Товчдоо, биг банг аргачлал нь бүтцийн том өөрчлөлт хийхийг хэлдэг бол консерватив аргачлал нь аядуу шилжилт хийхийг хэлдэг.<sup>[13]</sup>

болгож, түүний соёлыг төлөвшүүлснээр илүү хүртээмжтэй хөгжлийг буй болгоно хэмээн үзэж байна.<sup>[7]</sup>

- **Таван жилийн төлөвлөгөө.** Хятад үндэсний эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх ажлыг 5 жилээр төлөвлөж, хянах боломжтой гэж үзэн 1953 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн асуудлууд, үндэсний томоохон бүтээн байгуулалтын төслүүд, эдийн засгийн бүтцийн тохируулга, нийгмийн хөгжил болон хүрээлэн буй орчныг хамгаалах үзүүлэлтүүдийг багтаадаг. Уг төлөвлөгөө засаглалын тогтолцооны чухал хэсэг бөгөөд урьдчилан харах, залгамж чанар, хэрэгжих боломжийг тусгаж хийгддэг.<sup>[2] 1</sup>

### **Хоёр. Хятад эдийн засгийн өндөр өсөлтийг хэрхэн бий болгосон бэ**

1978 оны 12 дугаар сард ХКН-ын XI төв хорооны III бүгд хурлаар гаргасан “Шинэтгэл ба нээлттэй бодлого”-ын түүхэн шийдвэр нь Хятадын эдийн засгийн өсөлтийн эрин үеийг эхлүүлэв. Тухайн үед шинэ тогтолцоо ямар байх талаар тодорхой зорилго тавьж чадаагүй, өөрөөр хэлбэл, сайн боловсруулсан стратеги, бодлогын арга хэмжээ байгаагүй. Шинэтгэл нь ерөнхийдөө Дэн Сяопиний “Гишгэх чулуу бүрээ тэмтэрч гол гатлах”, “Муур цагаан эсвэл хар байх чухал бус харин хулгана барьдаг байх” философийн дагуу болгоомжтой бөгөөд прагматик зарчмаар явагджээ.

1980-аад онд Хятадын хамгийн их үр дүн өгсөн эдийн засгийн бодлого бол “ХАА-н шинэчлэл” болон “Нээлттэй хөгжил”-ийн бодлого юм. Хөдөөд хэрэгжүүлсэн “Хамтарсан үйлдвэрлэл, хариуцлагын тогтолцоо”-ны гол онцлог нь тариачид төлөвлөгөөгөө давуулан биелүүлбэл илүү гарсан бүтээгдэхүүнээ өөрсдөө авч болох урамшууллын системийг бий болгосон. Энэ бодлого хэрэгжсэнээр ихэнх хүн амын амьжиргааны түвшин дээшилж, хожим илүү гүнзгий шинэтгэл хийх суурь болж өгчээ.

Нээлттэй хөгжлийн бодлогын хувьд, 1960, 70-аад онд Азийн зарим улсад амжилттай хэрэгжүүлсэн “Экспортын боловсруулах бүс”-ийн туршлагад үндэслэн 1979 онд эдийн засгийн тусгай бүсүүдийг (цаашид ЭЗТБ гэх) байгуулах шийдвэр гаргасан. Хонконг, Макао түшиглэн Шэньжэн, Жүхайг, Тайванийн хаяанд Сямэнийг, Хойд Гуандунын эрэг дээр Шаньтоуг байгуулсан. Ийнхүү ЭЗТБ-үүдийг өндөр технологи импортлох, экспортыг нэмэгдүүлэх, гадаад валют олох, ажлын байр бий болгох, гадны менежмент, бизнес эрхлэх ур чадварыг шингээх, гадаадын хөрөнгө оруулалтыг (цаашид ГХО) татах зорилгоор эргийн дагуу байгуулсан, нөгөө талаас нөхцөл байдал буруугаар эргэвэл төвөөс хол байлгах зорилгыг агуулж байжээ. Түүнчлэн гадаад худалдааг гадаад худалдааны яам болон хэдхэн төрийн өмчит корпораци хянаж, монополюдож байсныг задалж, олон

1 Хятад улам бүр зах зээлжих хэрээр эдгээр төлөвлөгөөний эдийн засгийн тодорхой салбар дахь ач холбогдол буурч байгаа, гэхдээ эрчим хүчний бодлого, дэд бүтцийн томоохон төслүүдэд төрөөс хөрөнгө оруулалт (ХО) хийх зэрэг тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход чухал байсаар байна.<sup>[3]</sup>

улсын худалдааг өргөжүүлж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг (цаашид ГШХО) зөвшөөрч эхэлсэн.<sup>1</sup>

Үргэлжлүүлэн төвлөрлийг сааруулах бодлого хэрэгжүүлж, 1979 оноос төсвийн болон захиргааны эрх мэдлийг төв засгийн газраас муж, доод шатанд шилжүүлсэн. Өөрөөр хэлбэл, бүс нутаг хоорондын өрсөлдөөнийг дэмжих улс төрийн бүтэц үүсгэж, орон нутгийн засгийн газар орон нутгаа хөгжүүлбэл урамшуулдаг болжээ. Орон нутгийн засаг захиргаанд томоохон хөрөнгө оруулалтын төсөл батлах эрх олгох, өмнө төв засгийн газрын мэдэлд байсан төрийн өмчит үйлдвэрийн газар (цаашид ТӨҮГ)-уудыг орон нутгийн мэдэлд шилжүүлэх зэргээр орон нутаг өөрийн үйлдвэрлэлийн бодлогыг тодорхойлох, санхүүгийн байгууллагуудын нөөцийг ашиглахад илүү чухал үүрэг гүйцэтгэх боломжийг олгосон.

Шинэтгэлийн явцад, Хятадын эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгүүр төрийн өмчит бус харин хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд байсан. 1978 онд хувийн өмчийн ААН-үүдийн эдийн засагт эзлэх хэмжээ 22 хувь байсан бол 2012 онд 68 болж өссөн бөгөөд энэ нь голчлон хөдөөгийн хот, тосгодын ААН-үүд хурдан байгуулагдаж, өргөжин тэлсний үр дүн байв.

1980-аад оны сүүлч, 1990-ээд оны эхэн үеийн шинэтгэлийн 2 дахь үе шат нь ААН-ийн бие даасан байдлыг өргөжүүлэх замаар ТӨҮГ-уудын засаглалыг сайжруулах, зах зээлийн институциудыг бий болгох замаар эдийн засгийг захиргааны удирдлагаас үнэд суурилсан зах зээлийн эдийн засагт шилжүүлэх зорилгод чиглэгдсэн. Тухайлбал, үнийн шинэчлэлийг “хоёр үнэ”-ийн тогтолцоог ашиглаж хийсэн, үүнд зарим бүтээгдэхүүн, үйлчилгээг төрийн хяналттай үнээр хуваарилж, харин заримыг нь зах зээлийн үнээр хуваарилж эхэлсэн, улмаар зах зээлийн үнээр хуваарилах бүтээгдэхүүнийг аажим нэмэгдүүлж 1990-ээд оны дунд үе гэхэд бараг бүх бүтээгдэхүүнийг зах зээлийн үнэд шилжүүлжээ.

1990-ээд оны сүүлчээр төрийн өмчит ААН-үүдийг дампууруулах, нэгтгэх, дахин бүлэглэх замаар шинэчилж бэхжүүлсэн.<sup>2</sup> Төрийн өмчит ААН-ийг ажилчиддаа орон сууц, эмнэлэг, сургуультай болгох зэрэг нийгмийн чиг үүргээс салгаж, 100 хувь төрийн өмчит болон холимог өмчит болгон ангилж, засгийн газар хувьцааны 50-иас дээш хувийг эзэмших хязгаарлалтыг зөөлрүүлсэн. Түүнчлэн банкны систем дэх төлбөрийн чадваргүй байдлыг шийдвэрлэв. Гол зорилго нь улс төрийн захиалгаар бус эдийн засгийн бодлогыг мөнгөний бодлогоор хянах,

---

1 ГШХО Хятадын эдийн засгийн хөгжилд олон талын хувь нэмэр оруулсан, тухайлбал, нийт аж үйлдвэрийн гарцад ГХО-тай ААН-ийн эзлэх хувь 1993 оны 9.2 хувиас 2002 онд 33.4 хувь болж, харин нийт экспортод эзлэх хувь 1993 онд 27.5 хувь байсан бол 2002 онд 52.2 хувь болж тус тус өссөн. Түүнчлэн ГХО-тай ААН-үүд үйлдвэрлэл, технологийн хөгжилд их хувь нэмэр оруулж тус улсын өндөр технологийн бүтээгдэхүүн жилээс жилд нэмэгдэж байна. Мөн Хятадын ГШХО-ыг Хонконг, Тайвань, Сингапур зэрэг хятад үндэстэн голлосон орнуудаас хошуучлан хийсэн байдаг. Тухайлбал, 2019 оны байдлаар Тайванийн бизнес эрхлэгчдийн Хятадад оруулсан нийт ХО-ын хэмжээ 186.51 тэрбум ам.долларт хүржээ.

2 Тухайлбал, аж үйлдвэрийн салбарын төрийн өмчит ААН-үүдийн тоо 1995 онд 118000 байсан бол 2003 онд 23228 болж буурсан.

ашиг алдагдалд тулгуурлан зээл олгох чадвартай банкны системийг бий болгоход чиглэгдэж байв.<sup>[4] [5]</sup>

Эдгээр бодлогын үр дүнд, Хятад төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн, ХАА-н эдийн засгаас аж үйлдвэрийн, хаалттай эдийн засгаас нээлттэй эдийн засаг болжээ. Тухайлбал, 1978 онд төрийн өмчит ААН-үүд аж үйлдвэрийн нийт гарцын 77.6 хувийг үйлдвэрлэж байсан бол 2003 онд энэ хэмжээ 13.0 хувь болон буурч, эдийн засаг дахь төрийн үүрэг оролцоо эрс багассан. 1978 онд худалдааны салбар ДНБ-ний 9 хувийг эзэлж байсан бол 2004 онд 70 хувьд хүрч, дэлхийн худалдаа, үйлдвэрлэлийн интеграцид гүнзгий оржээ.<sup>1</sup> Дүгнэвэл, энэхүү шилжилтийн 30 орчим жилд дараах голлох бодлого, арга зам амжилтад хүргэсэн байна.

- Бусдын үзэл санаа буюу ямар нэг “изм”-д баригдаагүй бодит үр дүнгээр хэмжсэн прагматик хөгжлийн бодлого, түүнийг дэмжих хөрс суурийг бүрдүүлсэн.<sup>2</sup>
- Аажим ахиулах аргачлал шинэтгэлийн эхэн үеийн тодорхойгүй байдлыг бууруулж цаашид амжилттай үргэлжлэх үндэс суурийг бий болгосон.<sup>3</sup>

### Гурав. Хятадын хөгжлийн бодлогын хувьсал

30 гаруй жилийн эдийн засгийн хурдацтай өсөлтийн дараа Хятадын эдийн засгийн нөөцүүдийн үнэ, ашигт байдал аажмаар өөрчлөгдөж, хямд, элбэг хөдөлмөрийн хүчний давуу байдлаа алдаж эхлэв. Улмаар 2008 оны дэлхийн санхүүгийн хямралын дараа олон улсын эдийн засгийн орчин мэдэгдэхүйц доройтож, хямд үнэтэй экспортыг түшиглэж байсан Хятадын хөгжлийн загварт томоохон сорилт тулгарав. Түүнчлэн тус улсын ДНБ хурдтай өсөхийн хэрээр бүтцийн тэнцвэргүй байдал, орлогын тэгш бус байдал, байгаль орчны бохирдол, нөөцийн хомсдол, бодлогын үр дүн тааруу байх зэрэг эдийн засагт үзүүлэх дарамт нэмэгджээ.

Улмаар XII таван жилийн төлөвлөгөө (2012-2016)-ний эдийн засгийн хөгжлийн бодлого экспортоос дотоодын хэрэглээнд шилжих, үүнд дэд бүтцийн бүтээн байгуулалтыг нэмэгдүүлж эдийн засгийг идэвхжүүлэх, хэрэглээг дэмжих, үйлчилгээний салбарыг хөгжүүлэх болон аж үйлдвэрийн салбарыг шинэ түвшинд

- 
- 1 Хятадын худалдааны салбар үндсэндээ “боловсруулах” болон “угсрах” үйлдвэрлэлийн экспорт дээр тогтдог. Боловсруулах үйлдвэрлэл нь тухайн салбарын дэлхийн нийт үйлдвэрлэлийн 50 гаруй хувийг эзэлдэг. Түүнчлэн гадаадын ХО-тай ААН тус улсын нийт экспортын 50 гаруй хувийг үйлдвэрлэдэг онцлогтой.
  - 2 Аливаа шинэтгэл амжилттай хэрэгжих эсэх нь иргэдийн улс төрийн дэмжлэгээс ихээхэн хамаардаг, өөрөөр хэлбэл, хүн амын дийлэнх хэсэгт бодит үр өгөөж өгч буй эсэхээс хамаардаг. “Хоёр үнэ”-ийн урамшууллын арга энэ зорилгод хүрэх гол механизм болжээ.
  - 3 Үндэсний хөтөлбөр зарлаж хэрэгжүүлэхийн оронд тухайн санаачлагыг орон нутагт эсвэл тодорхой салбарт хэрэгжүүлдэг бөгөөд өргөн туршилт хийсний дараа амжилттай хэрэгжвэл улс даяар хэрэгжүүлдэг. Аажим нэвтрүүлэх нь бүтцийн талаарх туршлага болон дараагийн шатанд шинэчлэлийн хөтөлбөрийг дэмжигчдийн орлогыг бүрдүүлж, хууль журам, санхүүгийн систем зэрэг зах зээлийг дэмжих институцийг бий болгодог.

гаргах болж шинэчлэгдэв.

ХКН-ын XVIII Их хурал (2012.11.15-нд сонгогдсон)-ын дараагаас Хятадын хөгжлийн бодлого дараах өөрчлөлт, шинэчлэлийг агуулж байна:

- Экспорт, хөрөнгө оруулалтын тулгуураас хэрэглээний тулгуурт шилжих
- Эдийн засгийн гол хөдөлгөгч хүчийг аж үйлдвэрийн салбараас үйлчилгээний салбарт шилжүүлэх
- Хотжилтыг дэмжих замаар хот, хөдөөгийн болон бүс нутаг хоорондын хөгжлийн ялгааг багасгах
- Нийлүүлэлтийн шинэчлэл хийх замаар үйлдвэрлэлийн илүүдэл хүчин чадлыг арилгах<sup>1</sup>
- Цөм технологийн бүрэлдэхүүн хэсэг (upstream components) хөгжүүлж нийлүүлэлтийн сүлжээг бий болгох<sup>2</sup>
- Инноваци болон “Хятадад үйлдвэрлэв 2025” бодлогоор дамжуулан үйлдвэрлэлийн шилжилтийг ахиулах<sup>3</sup>
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх замаар орлогын хуваарилалтыг сайжруулах
- Байгаль орчныг хамгаалах замаар амьдралын чанарыг дээшлүүлэх
- Худалдааны чөлөөт бүсийг тараан байршуулах замаар худалдааны салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх
- “Бүс ба зам” санаачилга болон АДБХОБ<sup>4</sup>-аар дамжуулан гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх.<sup>[6]</sup>

Дүгнэвэл, энэ хугацаанд Хятадын хөгжлийн стратегийн гол чиглэл тогтвортой өсөлтийг хангах, ДНБ-ний тоон өсөлтөөс чанарын буюу “эдийн засгийн тэнцвэртэй хөгжил”-д шилжих болж өөрчлөгджээ. Эдийн засгийн шилжилтийг хурдасгаж гадаад зах зээлээс үүдэх цочролыг бууруулахаас гадна, зөвхөн ДНБ-ийг чухалчлах бус, нийгмийн тэгш байдал, орчны эрүүл ахуй зэрэг үндэсний хөгжлийн бусад үзүүлэлтийг анхаарч байна.

2012 оноос олон улсад Хятадын эдийн засгийн хөөс хагарч хатуу газардах,

---

1 Хятадын дундаж болон хямд үнэтэй бүтээгдэхүүн илүүдэлтэй, харин өндөр зэрэглэлийн бүтээгдэхүүний нийлүүлэлт хангалтгүй байгаа. Нүүрс, ган, цемент, шил, нефть хими, газрын тос, төмрийн хүдэр, өнгөт металл зэрэг салбарт бүтээгдэхүүний чанар тааруу, эрэлтийг хангаж чадахгүй байна. Нийлүүлэлтийн шинэчлэлийн томоохон зорилго нь илүүдэл үйлдвэрлэлийг зах зээлээс шахах юм.

2 2013 онд Хятадын боловсруулах үйлдвэрлэлийн гарц 2.74 их наяд ам.доллар болж, дэлхийн нийт гарцын 20 орчим хувийг бүрдүүлсэн. Гэсэн ч тус салбарын инновацийн чадавх, ГХО-аар хязгаарлагдсан цөм технологи, олон улсын брэндийн хомсдол, бүтээгдэхүүний чанар доогуур байгаа нь "том боловч хүчтэй бус" гэх ангилалд оруулсан. 2014 онд хагас дамжуулагч, чип зэргийн үйлдвэрлэлийг дэмжиж 120 тэрбум юанийн ХО-ын сан байгуулсан. Гэхдээ силикон чип болон бусад бүрэлдэхүүн хэсгүүдийг эзэмших, үйлдвэрлэх өртөг, эрсдэл өндөр, тус салбарын мэргэжилтнүүд Хятад эдгээр бүтээгдэхүүний гадаад хараат байдлаас хурдан салж чадахгүй гэж үзэж байна.<sup>[3]</sup>

3 “Хятадад үйлдвэрлэв 2025” төлөвлөгөөнд технологийн дэвшлийг ялангуяа өгөгдөл, нисэх онгоцны хөдөлгүүр, эко автомашиныг чухалчилсан. 2025 он гэхэд аж үйлдвэрийн инновацийн 40 төвийг бий болгох, үйлдвэрлэлийн үндсэн материалын 70 хувийг дотоодоосоо хангахыг зорьж байна.

4 Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк

санхүүгийн хямрал нүүрлэнэ гэх хандлага нилээд байсан хэдий ч Хятадын эдийн засаг тогтвортой өсөлтийг хадгалж, үйлчилгээний салбарын эзлэх хувь аажим нэмэгдэж байгаа нь тус улсын эдийн засгийн бодлого үр дүнтэй байгааг харуулж буй (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Хятадын ДНБ өсөлт ба ДНБ-д салбаруудын эзлэх хувь

Он	ДНБ-ний өсөлтийн хувь	Хөдөө аж ахуйн салбар (ХАА, МАА, ой, загас г.м)	Аж үйлдвэрийн салбар	Үйлчилгээний салбар
2010	10.4	9.5	46.4	44.1
2011	9.2	9.4	46.4	44.2
2012	7.8	9.4	45.3	45.3
2013	7.8	9.3	44.0	46.7
2014	7.3	9.1	43.1	47.8
2015	6.9	8.8	40.9	50.2
2016	6.7	8.6	39.9	51.6
2017	6.9	7.6	40.5	51.9
2018	6.6	7.0	39.7	53.3
2019	6.1	7.1	39.0	53.9

Эх сурвалж: Хятадын статистикийн мэдээллүүд, *stats.gov.cn* болон бусад

### Дөрөв. Хятадын хөгжлийн бодлогын цаашдын чиг хандлага

2015 оноос хойш явуулж буй Хятадын хөгжлийн бодлогыг багцлан харвал, тус улс өмнөх бодлогын сул талыг зассан, цаг үеэ мэдэрч сайжруулалт хийсэн, орчин үежих (модернизаци) алхамуудыг тууштай хийсээр байна, эдгээр бодлогыг товч дурдвал,

- Инновацийн хөдөлгүүртэй хөгжил. Үүнд, инновацид суурилсан цогц системийг бий болгох, инновацийн соёлыг төлөвшүүлэх, өндөр технологийн орц гарцыг нэмэгдүүлэх.
- Зах зээл голлосон хөгжил. Засгийн газрын хөрөнгө оруулалт, хэрэглээний зах зээл дэх оролцоог багасгах, төрийн өмчийн суурь шинэчлэлийг хурдасгах, өмчийн олон төрөлт эдийн засгийг идэвхжүүлэх.
- Бүтцийн тэнцвэртэй хөгжил. Системчилсэн эдийн засгийн концепцийг бий болгосноор, салбаруудын бүтэц харилцан уялдаж, эмх цэгцтэй хөгжих.
- Нөөцийн хэмнэлттэй хөгжил. Үүнд, чанартай хөгжлийг чухалчлах, аль болох бага нөөцөөр илүү их эдийн засгийн үр ашгийг авчрах, үр ашиг багатай орцыг багасгах.
- Ногоон хөгжил. Байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, экологийн нөхөн олговрын механизмыг бий болгох, илүү ногоон болох.

- Хүн төвтэй хөгжил. Иргэдийн орлогын түвшин, хэрэглээний чадавхийг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, боловсрол, амралт, ажил эрхлэлтийн нөхцөлийг баталгаажуулж, хөгжлийн үр өгөөжийг иргэд бүрэн хүртэх боломжийг олгох.<sup>[7]</sup>

#### XIV таван жилийн төлөвлөгөө

2020 оны 10 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд ХКН-ын XIX Төв Хорооны V бүгд хурлаар үндэсний эдийн засаг, нийгмийн хөгжлийн XIV таван жилийн төлөвлөгөө (2021-2025) болон 2035 оны урт хугацааны зорилтыг боловсруулах тухай саналыг батлав. Цар тахал дэгдсэн энэ үед, эдийн засгийн сэргэлтийг хангах, технологийн хувьд биеэ даах, цэргийн хүчээ бэхжүүлж эдийн засаг, улс төрийн ашиг сонирхлоо хамгаалахаа ХКН мэдэгдэв. Хятадын шинэ бодлого гадны шахалтын эсрэг зогсох, эдийн засгийн хараат бус байдлыг бэхжүүлэх стратегид шилжиж байна.<sup>[3]</sup>

Уг төлөвлөгөөний төсөлд эдийн засгийн өсөлтийн тоон зорилт тусгалгүйгээр гол төлөв чанарын илэрхийлэл санал болгосон, тухайлбал, эдийн засгийн бүтцийн оновчтой байдал, илүү цэвэр өсөлтөд гол анхаарлаа хандуулах ажээ.<sup>1</sup> Харин 2035 оны алсын хараанд нэг хүнд ногдох ДНБ-ийг дундаж хөгжингүй орнуудын түвшинд хүргэх зорилтыг дэвшүүлэв. Ши Жиньпин “2035 он гэхэд эдийн засгийн нийт хэмжээ болон нэг хүнд ногдох дундаж орлогыг 2 дахин нэмэгдүүлэх бүрэн боломжтой” хэмээсэн.<sup>[8][9]</sup>

XIV таван жилийн төлөвлөгөөнд гадаад орчны өөрчлөлтийг тооцож аюулгүй байдлыг чухалчилсан, давуу талаа түшсэн, сул талаа нөхсөн, түүнчлэн илүү орчин үеийн, өндөр түвшний амбицтай зорилтууд тусгажээ. Эдгээрээс дурдвал,

- Өөрийн бий болгосон технологи. Шинжлэх ухаан, технологи бие даах нь үндэсний хөгжлийн стратегийн гол дэмжлэг болно гэж үзэж буй.
- Эдийн засгийн бүх салбарт инновацийг дэмжих. Тухайлбал, орчин үеийн технологи бүхий өндөр үр ашигтай ХАА-г бий болгох.
- Хоёр эргэлт стратегийг хэрэгжүүлэх. Худалдааг гол болгосон гадаад, хэрэглээг гол болгосон дотоод гэсэн хос эргэлтээр эдийн засгийн өсөлтийг бий болгох, гэхдээ гол анхаарлаа дотоод эргэлтэд тавина.<sup>2</sup> Дотоодын хэрэглээний бүтцийг сайжруулж гадаад эрэлтийн цоорхойг нөхөх, үүнд, соёл, аялал жуулчлалын цогц хөгжлийг дэмжих, орчин үеийн үйлчилгээний салбарын стандартчилал, брэндчиллийг дэмжих г.м.

1 ДНБ-ний өсөлтийн зорилтот түвшингээс татгалзсан нь цар тахал, Хятад, АНУ-ын сөргөлдөөн г.м тодорхойгүй хүчин зүйл багагүй байгаатай холбоотой. Мөн тус улс 2060 он гэхэд "нүүрстөрөгчийн нейтрал"-д хүрэх зорилт тавьсан. Энэ нь ногоон бүсийг бий болгох, сэргээгдэх эрчим хүч ашиглах зэргээр хүний үйл ажиллагаагаар бий болох хүлэмжийн хий ялгаруулахгүй гэсэн үг.

2 Хятадын шинэтгэл, нээлттэй бодлогын гол зорилго гадаадын ХО, нөүхау-г татаж үйлдвэрлэгч улс болох, экспортын давамгайллаар ЭЗ-ийн өндөр өсөлтийг хангах зэрэг гадаад хүчин зүйл байсаар ирсэн. Үүний угтвар нөхцөл нь Хятад, Барууны ялангуяа Хятад, АНУ-ын тогтвортой харилцаа юм. Гэвч тус улсуудын сөргөлдөөн ужгирч, Хятад даван туулахын тулд аль болох гадаад орчны хамаарлыг багасгахыг зорьж байна.

- Үйлдвэрлэлийн бааз, гинжин хэлхээний модернизацийг бий болгох. Үүнд, стратегийн шинэ тутам хөгжиж буй үйлдвэрлэлийн салбарууд болох шинэ үеийн мэдээллийн технологи, биотехнологи, шинэ эрчим хүч, шинэ материал, өндөр түвшний тоног төхөөрөмж, шинэ эрчим хүчний автомашин, сансар огторгуй, далайн гүний судалгаа зэрэг салбар хамаарч байна.<sup>1</sup>
- Интернет, өгөгдөл, хиймэл оюун зэрэг салбарын гүнзгий интеграцийг дэмжих, шинэ дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хурдасгах. Үүнд, 5 дахь үеийн хөдөлгөөнт харилцаа холбоо, аж үйлдвэрийн интернэт, өгөгдлийн төвүүдийг барих, дижитал эдийн засгийн аж үйлдвэрийн кластеруудыг хөгжүүлэх зэрэг зорилт голлож буй.<sup>[11]</sup>

### Тав. Дүгнэлт

Хятад эдийн засгийн өндөр өсөлтийг зах зээлд талтай эдийн засаг<sup>2</sup>, түүний тогтвортой байдлаар, бодит үр дүн өгч буй бодлогыг дэмжих замаар хангажээ. Харин тодорхой хугацааны дараа тухайн бодлогын үр ашиг буурах үед засвар, шинэчлэлийг цаг алдалгүй хийсээр байна, өөрөөр хэлбэл, зах зээлийг төгөлдөршүүлж, чөлөөт зах зээлийн тогтолцоо<sup>3</sup> бий болгох чиглэл рүү явж байна.

Сүүлийн үеийн стратегийн чиг хандлага нь эрсдлээс урьдчилан сэргийлсэн, нийтийн хөгжил цэцэглэлтийг чухалчилсан, тогтвортой өсөлтийг аль болох өөрийн нөөц бололцоогоор хангах болж шинэчлэгджээ. Зөвхөн эдийн засгийн тоон өсөлтийг бус чанарыг, хүний хөгжил, ногоон хөгжил зэрэг бусад хөгжлийн үзүүлэлтийг анхаарах, инновациар нэмүү өртөг шингээх бодлогыг чухалчилж байна.

2019 оны байдлаар Хятадын нэг хүнд ногдох ДНБ 10260 ам.доллар болж өндөр орлоготой орнуудын босго болох 12700 ам.долларт дөхсөн, түүнчлэн ирэх 15 жилд уг орлогыг 2 дахин өсгөх зорилт тавьж буйгаас харахад, тус улс “дунд орлогын занга”-аас мултарч, дундаж хөгжингүй орны түвшинд хүрэх, Азийн бар орнуудын хөгжлийн төр засаг загвар (Developmental state model) болж төлөвших боломж өндөр байна.

Гэхдээ тус улсын дотоодод орлогын тэгш бус байдал, өрхүүдийн өр, хөдөлмөрийн насны хүн амын бууралт зэрэг багагүй асуудал байгаа бөгөөд эдийн засгийн өсөлт удааширч байгаагаас өмнөх өндөр өсөлтөөр эрсдлийг зөөлрүүлж байсан бодлогод томоохон сорилт тулгарч буй. Энэ үед нөөц ашиглалтын үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд зах зээлжих явцыг түргэсгэх шаардлагатай байдаг,

1 Тухайлбал, 2019 онд Хятадын 100 хувь цахилгаан автомашины борлуулалт 5% байгаа ба 2025 он гэхэд 20%, 2030 онд 40%, 2035 онд 50% хүртэл өсгөх, үлдсэн 50%-ийг гибрид автомашин болгох, улмаар 2035 он гэхэд ердийн бензин автомашины үйлдвэрлэл, борлуулалтыг зогсоох ажээ.<sup>[10]</sup>

2 Товчдоо, энэ онолоор төр зах зээлийг ажиллуулах ёстой институцийг бий болгох зэргээр зах зээлийн хувьд зохицуулагчийн үүрэг гүйцэтгэдэг.

3 Чөлөөт зах зээлийн онолоор чөлөөт зах зээл, өрсөлдөөн хамгийн үр дүнтэй, харин төрийн оролцоо хамгийн үр дүнгүй гэж үздэг.

гэвч нийлүүлэлтийн шинэчлэл, “Бүс ба зам” зэрэг гол бодлогыг төрийн яамд удирдаж, төрийн өмчийн ААН-үүд хэрэгжүүлж, төрийн өмчит ААН-ийн шинэтгэл төрөөс тус ААН-үүдийг хянахад төвлөрч байгаа нь эдийн засаг дахь төрийн оролцоог нэмэгдүүлж, зах зээлийн үүргийг сулруулж байгаа ажээ. Гадаад талдаа АНУ-тай хийж буй стратегийн өрсөлдөөн голлох сорилт болж байна.

### Зургаа. Монгол Улсын анхаарах асуудал

Монгол Улс хэдийгээр 30 жилийн өмнө ардчилсан тогтолцоо, чөлөөт зах зээлийн эдийн засаг руу зоримог шилжилт хийсэн боловч сүүлийн жилүүдэд эдийн засгийн эрх чөлөө болон засаглалын бусад үзүүлэлтээр ухралт хийсээр байна,<sup>1</sup> товчдоо, буцаад зах зээл дэх төрийн оролцоог нэмэгдүүлж байна.<sup>2</sup>

Эдийн засгийн эрх чөлөө хязгаарлагдмал байгаа нь ААН-үүд шударга өрсөлдөх орчин хомс, авлига, танил талаар давуу байдал үүсгэх, нийтийн албыг хувийн сонирхолд ашиглах замаар илэрхийлэгдэж буй, өөрөөр хэлбэл, эдийн засгийн хөгжлийг сайн засаглал, мэргэшсэн төрийн алба, шударга шүүхгүйгээр хангах бололцоогүй.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд, 1 дүгээрт, эдийн засгийн систем тэнцвэртэй байх, 2 дугаарт, хөгжил дэвшил өөрөө аюулгүй байдлыг хангах нөхцөл гэсэн дуализмыг илэрхийлсэн.<sup>[12]</sup> Хятадын эдийн засгийн өсөлтөд дулдуйдаж эдийн засгаа өсгөх, ингэхдээ санхүү, үйлдвэрлэл, технологийн хараат байдалд орохгүй байх гэсэн томоохон сорилт бидэнд тулгарч байна. Цаашид Хятадын хөгжлийн бодлогыг нарийвчлан судлах, эдийн засгийн хөгжлийн богино, дунд хугацааны бодлогодоо уялдуулах нь зүйтэй болов уу. Түүнчлэн эдийн засгийн бие даасан байдлыг хангах бодлогыг хурдтай, тууштай хэрэгжүүлэх, технологийн хөгжилд хөрөнгө, хүч хаях зайлшгүй шаардлага байна.

Эцэст нь хэлэхэд, Хятадын эдийн засгийн хөгжилд Хонконг, Тайвань, Сингапур зэрэг элэг нэгтнүүдийнх нь оруулсан хувь нэмэр асар их. Өнөөгийн нөхцөлд Монгол Улсыг хөгжил дэвшил рүү замчлах “элэг нэгтнүүд” бол гуравдагч хөрш буюу ардчилсан, өндөр хөгжилтэй улсууд байх боломжтой. Гуравдагч хөршүүдтэйгээ улс төр, эдийн засаг, соёлын салбарт хоёр болон олон талт харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх нь стратегийн тэнцвэрийг хангах чухал хүчин зүйл болж байна.

---

1 Эдийн засгийн эрх чөлөөний индексээр Монгол Улс 2005 онд дэлхийд 50 дугаар байрт байсан бол 2020 онд 127 дугаар байрт орж ухарсан. Манай улс шүүхийн үр нөлөө, төсвийн сахилга бат зэрэг үзүүлэлтээр хамгийн муу оноо авчээ. Харин Хятад 2020 онд 103 дугаар байрт байна.

2 Тухайн улсад тохирсон хөгжлийн бэлэн жор байхгүй бөгөөд өөрийн улсын онцлогыг харгалзаж аргачлалаа сонгодог. Монгол Улс биг банг аргачлалаар шилжилт хийж, либералчлал, хувьчлалын бодлого явуулсан. Зарим нэр хүндтэй эдийн засагчид үүнийг зөв, өөр арга байгаагүй, асуудал нь уг бодлогыг дундаас нь зогсоосонд оршино гэж үздэг.<sup>[13]</sup>

**Ашигласан эх сурвалж:**

- [1] He Li, The Chinese Model of Development and Its Implications, World Journal of Social Science Research, 2015 2(2), 128-138
- [2] 中国文化研究院、现代中国，五年规划，<https://ls.chiculture.org.hk/tc/idea-aspect/53>
- [3] Steven Lee Myers, 解读五中全会：中国下一个五年怎么走, 2020.10.30, cn.nytimes.com
- [4] Chen-yuan Tung, Overview of Chinese Economic Reforms: Initiatives, Approaches and Consequences, NCCU Taipei, 2005.09
- [5] 崔友平, 中国经济体制改革：历程、特点及全面深化, 经济与管理评论, 2018年、第6期、5-14
- [6] 李志強, 中國大陸經濟發展策略、趨勢與挑戰, Prospect & Exploration 第16卷、第 5 期, 2018年 5 月
- [7] 李书昊, 新时代中国经济发展方式转变的测度研究, Economist 2019-1, 53-61
- [8] 川手伊织, 中国力争2035年成为中等发达国家, 日本经济新闻, 2020. 10. 30
- [9] 多部田俊辅、川手伊织, 中国提出2035实现GDP或人均收入翻番可能, 日本经济新闻, 2020. 11. 04
- [10] 多部田俊辅, 中国2035年新车全改环保车、日系有利, 日本经济新闻, 2020. 10. 28
- [11] Rachel和Ken, 中國十四五規劃重點、帶來的三大投資機遇, 2020.11.13, macromicro.me
- [12] Ц.Даваадорж, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгасан эдийн засгийн аюулгүй байдлыг хангах онол, арга зүйн зарим асуудлууд, Стратеги судлал сэтгүүл, 2011, №53
- [13] А.Бат-Оргил, Хөгжлийн тухай онолууд Монголын хөрсөнд, 2018 он, УБ хот